



**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТОЙМ**


МХБ-ээр арилжигдсан уул уурхайн бүтээгдэхүүний 2025 оны эхний хагас жилийн арилжааны тойм

2025 оны эхний хагас жилд нийт 494 удаагийн уул уурхайн бүтээгдэхүүний цахим дуудлага арилжаа зохион байгуулагдсан байна. Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХХК, “Хангад Эксплорэйшн” ХХК, “Андын Илч” ХХК нь 2.34 сая тонн нүүрсийг 610.19 тэрбум төгрөгөөр, “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ, “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК нь нийт 2.96 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 630.51 тэрбум төгрөгөөр, “Очир Мандал Хайрхан” ХХК, “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь нийт 18,265 тонн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг 17.35 тэрбум төгрөгөөр, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ 20,000 тонн зэсийн баяжмалыг 139.53 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан бөгөөд нийт 5.33 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 1.4 их наяд төгрөгөөр арилжаалсан байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа

2025 оны эхний хагас жилд нийт 174 удаагийн арилжаа амжилттай зохион байгуулагдаж нийт 5,334,665 тонн уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалснаас нүүрсний арилжаагаар 2,336,000 тонн нүүрс, төмрийн арилжаагаар 2,960,400 тонн төмрийн хүдэр болон баяжмал, жоншны арилжаагаар 18,265 тонн хайлуур жоншны хүдэр болон баяжмал, зэсийн арилжаагаар 20,000 тонн зэсийн баяжмал тус тус арилжигдсан байна. Нийт арилжааны 55.5 хувийг төмрийн хүдэр, баяжмалын арилжаа, 43.8 хувийг нүүрсний арилжаа, 0.4 хувийг зэсийн арилжаа, 0.3 хувийг хайлуур жоншны хүдэр болон баяжмалын арилжаа тус тус эзэлж байна.

График 1. 2025 оны эхний хагас жилийн уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хэмжээнд эзлэх хувь.



1. Нүүрсний арилжаа


2025 оны эхний хагас жилд нийт 55 удаагийн нүүрсний дуудлага арилжаа амжилттай зохион байгуулагдаж 2,336.0 мянган тонн нүүрсийг 610 тэрбум 192.64 сая төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан нүүрсний үнийн өсөлтийн дундаж 6.47 хувь байна. Худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан нүүрсний үнийн өсөлтөөс нийт 4.7 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

Хүснэгт 1. 2025 оны эхний хагас жилд арилжигдсан нүүрсний хэмжээ, үнийн дүн.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжээ /тонн/	Үнийн дүн /төгрөг/
1	1/3 коксжих нүүрс	832,000	201,855,084,288
2	Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс	486,400	150,972,584,320
3	Баяжуулсан коксжих чанаргүй нүүрс	307,200	52,146,419,251
4	Баяжуулсан коксжих нүүрс	281,600	112,229,315,501
5	Баяжуулсан сул коксжих нүүрс	243,200	73,415,350,720
6	Эрчим хүчний нүүрс	108,800	13,635,671,520
7	Чийг багатай хүрэн нүүрс	76,800	5,938,214,400
Нийт		2,336,000	610,192,640,000


Нийт нүүрсний арилжааны үнийн дүнгийн 33.08 хувь буюу 201.86 тэрбум төгрөгийг 1/3 коксжих нүүрсний арилжаа, 24.74 хувь буюу 150.97 тэрбум төгрөгийг Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрсний арилжаа, 18.39 хувь буюу 112.23 тэрбум төгрөгийг Баяжуулсан коксжих нүүрсний арилжаа, 12.03 хувь буюу 73.42 тэрбум төгрөгийг Баяжуулсан сул коксжих нүүрсний арилжаа, 8.55 хувь буюу 52.15 тэрбум төгрөгийг Баяжуулсан коксжих чанаргүй нүүрсний арилжаа, 2.23 хувь буюу 13.64 тэрбум төгрөгийг Эрчим хүчний нүүрсний арилжаа, 0.97 хувь буюу 5.94 тэрбум төгрөгийг Чийг багатай хүрэн нүүрсний арилжаа тус тус эзэлж байна.

График 2. Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь /бүтээгдэхүүний ангиллаар/.



Нүүрсний арилжааны нийт үнийн дүнгийн 55.05 хувь буюу 335.91 тэрбум төгрөгийн арилжааг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 23.01 хувь буюу 140.39 тэрбум төгрөгийн арилжааг “Тавантолгой” ХК, 14.72 хувь буюу 89.83 тэрбум төгрөгийн арилжааг “Хангад Эксплорэйшн” ХХК, 6.25 хувь буюу 38.13 тэрбум төгрөгийн арилжааг “Энержи Ресурс” ХХК, 0.97 хувь буюу 5.94 тэрбум төгрөгийн арилжааг “Андын Илч” ХХК тус тус эзэлж байна.

График 3. Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь /худалдагч компаниар/.




2025 оны эхний хагас жилд нийт 55 удаагийн нүүрсний арилжаа амжилттай явагдсан. Үүнд:

- 1 дүгээр сард нийт 10 удаагийн нүүрсний арилжаагаар 256,000 тонн буюу 63.78 тэрбум төгрөгийн арилжаа,
- 2 дугаар сард нийт 4 удаагийн нүүрсний арилжаагаар 172,800 тонн буюу 59.17 тэрбум төгрөгийн арилжаа,
- 3 дугаар сард нийт 10 удаагийн нүүрсний арилжаагаар 249,600 тонн буюу 70.1 тэрбум төгрөгийн арилжаа,
- 4 дүгээр сард 21 удаагийн нүүрсний арилжаагаар 1,331,200 тонн буюу 348.29 тэрбум төгрөгийн арилжаа,
- 5 дугаар сард 4 удаагийн нүүрсний арилжаагаар 51,200 тонн буюу 16.32 тэрбум төгрөгийн арилжаа,
- 6 дугаар сард 6 удаагийн нүүрсний арилжаагаар 275,200 тонн буюу 52.53 тэрбум төгрөгийн арилжаа тус тус амжилттай зохион байгуулагдсан.

2. Төмрийн хүдэр, баяжмалын арилжаа

График 4. 2025 оны эхний хагас жилд арилжигдсан төмрийн хүдэр, баяжмал

2025 оны эхний хагас жилд нийт 109 удаагийн арилжаагаар 2,960,400 тонн төмрийн хүдэр, баяжмалыг 630.51 тэрбум төгрөгөөр арилжсан. Үүнд: 2,379,600 тонн буюу 502.04 тэрбум төгрөгийн төмрийн баяжмал, 580,800 тонн буюу 128.47 тэрбум төгрөгийн төмрийн хүдэр тус тус арилжигдсан байна. Тодруулбал: Fe – 65%-ийн төмрийн баяжмал 198,000 тонн буюу 59.21 тэрбум төгрөг, Fe – 58%-ийн төмрийн баяжмал 2,181,600 тонн буюу 442.84 тэрбум төгрөг, Fe-52%-ийн төмрийн хүдэр 580,800 тонн буюу 128.47 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийсэн байна. Үүнд



- 1 дүгээр сард 30 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 1,010,100 тонн буюу 207.9 тэрбум төгрөгийн арилжаа,
- 2 дугаар сард 21 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 917,400 тонн буюу 185.33 тэрбум төгрөгийн арилжаа,
- 3 дугаар сард 14 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 145,200 тонн буюу 37.83 тэрбум төгрөгийн арилжаа,
- 4 дүгээр сард 19 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 660,000 тонн буюу 144.98 тэрбум төгрөгийн арилжаа,
- 5 дугаар сард 12 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 92,400 тонн буюу 21.85 тэрбум төгрөгийн арилжаа,
- 6 дугаар сард 13 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 135,300 тонн буюу 32.62 тэрбум төгрөгийн арилжаа тус тус амжилттай зохион байгуулагдсан.

Дуудлага худалдаагаар арилжсан төмрийн хүдэр, баяжмалын үнийн өсөлтийн дундаж 4.33 хувь байна. Төмрийн хүдэр, баяжмалын арилжааны нийт үнийн дүнгийн 70.23 хувь буюу 442.84 тэрбум төгрөгийн арилжааг “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК, 29.77 хувь буюу 187.67 тэрбум төгрөгийн арилжааг “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ тус тус эзэлж байна.

График 5. Нийт төмрийн арилжааны үнийн дүнд эзлэх хувь /худалдагч компаниар/.



2025 оны эхний хагас жилд худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан төмрийн хүдэр, баяжмалын үнийн өсөлтөөс нийт 14.24 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

3. Зэсийн баяжмалын арилжаа

2025 оны эхний хагас жилд “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ нь нийт 20.0 мянган тонн 22.35%-ийн зэсийн агуулгатай баяжмалыг 139.53 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан зэсийн баяжмалын үнэ дунджаар 2.44 хувиар өсөж, худалдагч компани 2.51 тэрбум төгрөгийн нэмэлт орлого оллоо.

4. Хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжаа

2025 оны эхний хагас жилд нийт 6 удаагийн арилжаагаар 18,265 тонн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг 17.35 тэрбум төгрөгөөр арилжсан. Үүнд:

- 2 дугаар сард 1 удаагийн хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжаагаар 3,315 тонн буюу 4.1 тэрбум төгрөгийн арилжаа,
- 3 дугаар сард 3 удаагийн хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжаагаар 8,320 тонн буюу 6.1 тэрбум төгрөгийн арилжаа,
- 6 дугаар сард 2 удаагийн хайлуур жоншны баяжмалын арилжаагаар 6,630 тонн буюу 7.12 тэрбум төгрөгийн арилжаа тус тус амжилттай зохион байгуулагдсан байна.

Дуудлага худалдаагаар арилжсан хайлуур жоншны хүдэр, баяжмалын үнийн өсөлтийн дундаж 17.09 хувь байна. Тайлант хугацаанд “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь 13.3 мянган тонн CaF_2 -97%, CaF_2 -95%-ийн хайлуур жоншны баяжмалыг 15.6 тэрбум төгрөгөөр, “Очир мандал хайрхан” ХХК нь 5.0 мянган тонн $\text{CaF}_2 < 55\%$ -ийн хайлуур жоншны хүдрийг 1.7 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖАА, БҮРТГЭЛИЙН ГАЗАР